



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/120

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоол, аймгийн аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт цас их орж хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэн, мөн улсын Онцгой комиссоос өгсөн үүргийн дагуу Сэлэнгэ аймгаас 200 тонн малын тэжээлийн улаан буудай татах тээврийн зардалд 24,000.000 (Хорин дөрвөн сая) төгрөгийг, 24 цагаар ажиллаж байгаа аймгийн шуурхай штабын үйл ажиллагаа, албан хаагчдын хоолны зардалд 2,128.000 (Хоёр сая нэг зуун хорин найман мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Батлагдсан зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)- т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар)- д даалгасугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР